



**ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН
12 ДАХЬ УДААГИЙН**

**ЗАЛУУЧУУДЫН АЗИ ТИВИЙН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД
МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛӨН ӨРСӨЛДӨХ
ТАМИРЧДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ СОРИЛ ТЭМЦЭЭН**

2023.06.14



**“ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН 12 ДАХЬ УДААГИЙН ЗАЛУУЧУУДЫН АЗИ
ТИВИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛӨН
ӨРСӨЛДӨХ ТАМИРЧДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ СОРИЛ ТЭМЦЭЭН”-ИЙ
ЗААВАР**

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- 2023 оны есдүгээр сард Ливан улсад зохион байгуулагдах залуучуудын тивийн аварга шалгаруулах тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох тамирчдыг сонгон шалгаруулах

Зохион байгуулагч	Монголын Таеквондогийн Холбоо
Холбоо барих	8010-0471
E-mail	mongoliatekwondo@gmail.com
Facebook хуудас	www.facebook.com/mongoliatekwondo/
Бүртгэлийн систем	www.mongol-taekwondo.com

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Өдөр	Хөтөлбөр	Байршил
6 сарын 2-9	• Бүртгэл	www.mongol-taekwondo.com
6 сарын 13	• Тамирчдын жин үзнэ	Улаанбаатар хотын 4 бүсэд нэгэн зэрэг.
	• Тэмцээний техникийн зөвлөгөөн, сугалаа	Үндэсний шигшээ багийн зааланд
6 сарын 14	• Хяналтын жин • Тэмцээн	Спортын төв ордны А зааланд

- Заасан хугацаа хэтэрсэн тамирчны мэдүүлгийг хүлээн авахгүй!
- Сорил тэмцээнд Монголын таеквондогийн холбоотой гэрээтэй, албан ёсны гишүүн байгууллага түүний тамирчид оролцоно.
- Сорил тэмцээнд тамирчнаа оролцуулах байгууллага нь холбоонд гишүүнчлэлийн хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх.

ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

1. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

Тэмцээн Дэлхийн таеквондогийн холбооноос гаргасан шинэчилсэн дүрмийн дагуу явагдана.

2. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Оролцогч тамирчин нь Күккивоны хар бүс, дантай байх шаардлагатай.
- Тамирчин нь Монголын таеквондогийн цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна.
- Тулаан Daedo цахим хамгаалах систем дээр явагдана.
- Сорил тэмцээнд оролцогч нь хэрэв шалгарсан тохиолдолд Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд хувийн зардлаар явах боломжтой байх.
- Сорил тэмцээнд өрсөлдөн шалгарсан жиндээ Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоно.
- Жин тус бүрд шалгарсан тамирчин тэмцээн дууссанаас ажлын 3 хоногийн дотор баталгаажилтын 200 ам.долларыг холбоонд тушаана.

3. ЖИН

Залуучууд /15-17 нас/ /2006 оны 1 сарын 1-нээс 2008 оны 12 сарын 31-ний хооронд төрсөн тамирчид/

Эр		Эм	
- 45 кг	45 кг хүртэлх	- 42 кг	42 кг хүртэлх
- 48 кг	45 кг жингээс 48 кг жингийн хооронд	- 44 кг	42 кг жингээс 44 кг жингийн хооронд
- 51 кг	48 кг жингээс 51 кг жингийн хооронд	- 46 кг	44 кг жингээс 46 кг жингийн хооронд
- 55 кг	51 кг жингээс 55 кг жингийн хооронд	- 49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
- 59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд	- 52 кг	49 кг жингээс 52 кг жингийн хооронд
- 63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд	- 55 кг	52 кг жингээс 55 кг жингийн хооронд
- 68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд	- 59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд
- 73 кг	68 кг жингээс 73 кг жингийн хооронд	- 63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд
- 78 кг	73 кг жингээс 78 кг жингийн хооронд	- 68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд
+ 78 кг	78 кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 68 кг	68 кг жингээс дээш жинтэй тамирчид

- ❖ Жин тус бүрт заасан жиндээ багтаж орох хэрэгтэй ба заасан жингээс 100гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.
- ❖ Хуваарийн дагуу тулааны өмнө жингээ үзүүлэхээс гадна тэмцээний өглөө хяналтын жин давхар үзнэ.

4. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ

Тэмцээнд оролцогч нэг тамирчны дэвжээний төлбөр 40.000 (дөчин мянга)-н төгрөг

Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

5. ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН ГАРГАХ

- Жин тус бүрт түрүүлсэн тамирчин 2023 онд зохион байгуулагдах Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийн батламж гардан авах ба мөнгөн медаль хүртсэн тамирчин нөөц тамирчнаар бүргэгдэж нэгдсэн бэлтгэл сургуулилтад хамрагдах эрхтэй болно.
- Хэрэв аливаа жинд нэг оролцогч бүртгүүлсэн тохиолдолд тухайн тамирчин эрхийг шууд гардан авна.

6. ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦООЛОЛ

Огноо: 2023.9.2-4

Байршил: Ливан Берут хот

Зардлын нэр	Нэгж зардал	Нийт зардал	Тайлбар
Онгоцны билет		4.700.000₮	
Буудал, хоол	130\$	2.730.000₮	Нийт 6 хоног
Оролцогчийн хураамж	100\$	350.000₮	
ОУ-ын лиценз	35\$	122.500₮	
Визний хураамж			
Нийт зардал /Урьдчилсан байдлаар/		8 сая төгрөг	

Жич:

Энэхүү тооцоо нь урьдчилсан тооцоо бөгөөд зардлуудын дүнд өөрчлөлт орох магадлалтайг анхаарна уу.

Тэмцээний жин үзүүлэх болон бүртгүүлэх өдрүүд нь тэмцээний үргэлжлэх хоног дээр нэмэгддэг ба онгоцны нислэгийн хуваариас хамаарч байрлах өдөр тооцоологддог болно.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -